УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН БАРЬСАН “ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН АГУУЛГЫГ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа

АГУУЛГА

Оршил

Нэг. Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн өнөөгийн байдал, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн агуулгын тойм

Хоёр. Хөгжлийн бодлого төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлж байгаа бусад орны туршлага, эрх зүйн зохицуулалт

2.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг зохицуулж буй үндсэн бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж

2.2 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа баримтлах зарчим, тавигдах шаардлага

2.3 Хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын эрх, үүрэг

2.4 Бодлогын баримт бичгийн төрөл, санхүүжүүлэх эх үүсвэр

2.5 Бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах үе шат, процесс

2.6 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ, үнэлгээ

Ашигласан материал

ОРШИЛ

Судалгааны зорилго

Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн өнөөгийн байдал, бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо зэргийг тоймлон судлахаас гадна УИХ-д өргөн барьсан хуулийн төслийн гол агуулгыг тоймлон харуулах, хөгжлийн бодлого төлөвлөлтийн сайн туршлага бүхий орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалттай харьцуулан судлахыг зорьсон болно.

Судалгааны товч дүгнэлт

Аливаа улс үндэстний хөгжлийн бодлого нь олон арван жилийн түүхээсээ сургамж авч, өнөөгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилтуудаа оновчтой тодорхойлж, улмаар ойрын ирээдүй болон урт хугацаандаа ард иргэдэд сайн сайхан амьдралыг бий болгон баталгаажуулах явдал байдаг. Ингэхдээ хөгжлийн алтан гурвалжин болох нийгмийн тэгш байдал, эдийн засгийн өсөлт, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлуудыг ямагт анхаарлынхаа төвд, тэнцвэртэй байлгахад анхаардаг байна.

Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулсан орнуудын туршлагаас харахад судалгаа шинжилгээнд тулгуурлан хөгжлийн гол тэргүүлэх чиглэлээр цөөн тооны голлох салбаруудыг сонгож, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бусад салбартай уялдаа холбоо бүхий цөөн тооны зорилтуудыг дэвшүүлсэн байдаг байна[1]. Монгол Улсын хувьд одоо хүчин төгөлдөр мөрдөж буй дараах бодлогын баримт бичгүүд байна. Үүнд:

[1]“Хөгжлийн урт хугацааны бодлогын харьцуулсан шинжилгээ” Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2014 он.

- Үндэсний хөгжлийн цогц бодлого-1,
- Үндэсний хөтөлбөр-131,
- Дэд хөтөлбөр-12,
- Салбарын стратегийн бодлогын баримт бичиг-27,
- Салбарын мастер төлөвлөгөө-13,
- Салбарт төрөөс баримтлах бодлого-27,
- Үйл ажиллагааны төлөвлөгөө-61, нийт 272 бодлогын баримт бичиг байх бөгөөд эдгээр баримт бичгүүдэд дэвшүүлсэн *тэргүүлэх чиглэлийн зорилт-6, стратегийн зорилт-105, дэд зорилт-423* байна[2].

Ийнхүү олон тооны бодлогын баримт бичгийг батлан гаргаж зорилго зорилтуудыг дэвшүүлсэн ч бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо муу, дэвшүүлсэн зорилтуудын тоо их, үндэслэл тооцоо муутай, хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр болон хэрэгжүүлэх арга механизм тодорхойгүй явж ирснээс бодлогын зорилтуудын уялдаа холбоо алдагдаж хэрэгжүүлэх боломж хомсдохын хэрээр эдийн засгийн нөөц боломж, хүчийг сулруулах нөхцөл бүрдсэн гэж хэлж болохоор байна.

Энэхүү судалгааны явцад Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төсөлд тусгасан зохицуулалтын механизмуудыг төслийн үзэл баримтлалтай тулган нягталж, төсөлд тусгасан зарим зохицуулалтыг гадаадын зарим орны хөгжлийн бодлогын баримт бичигт хэрхэн тусгасан туршлагатай харьцуулан авч үзлээ.

Судалгаанд авагдсан ихэнх орнуудын хувьд Хөгжлийн бодлого төлөвлөлтийг зохицуулах тусгайлсан эрх зүйн зохицуулалт (хууль, тогтоомж) байхгүй байгаа боловч төрөөс урт хугацаанд баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулан баталдаг туршлагатай орнууд юм.

Судлагдсан орнуудын нийтлэг жишгээс харахад, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгээ 15–30 жилийн хугацаатайгаар төлөвлөн боловсруулах ба урт хугацааны бодлогын баримт бичгийн хүрээнд зорилтуудаа богино, дунд хугацааны үе шатаар нарийвчлан тодорхойлж төлөвлөх, богино дунд хугацаанд хүрсэн үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх системтэй байна.

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, УЛСЫН ИХ ХУРАЛД ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН АГУУЛГЫН ТОЙМ

Монгол Улс 1991 оноос хойш үндэсний хэмжээнд, салбарын болон салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр нийт 480 гаруй бодлогын баримт бичиг батлан гаргаснаас өнөөгийн байдлаар 272 бодлогын баримт бичиг хугацааны хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүдийг үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, стратеги, үндсэн чиглэл, төлөвлөгөө зэргээр нэрлэсэн байдаг.

Түүнчлэн хэрэгжих хугацаа, бодлогын зорилго, зорилт давхацсан, хоорондын уялдаа холбоо муутай олон тооны бодлогын баримт бичиг байгаагийн дээр хэрэгжилтийн хувьд тодорхойгүй, зорилго, зорилт болон тодорхойлсон үр дүндээ хүрэхгүй байгаа явдал байсаар байна. Энэ нь нэг талаараа бодлогын баримт бичгүүдийн хэрэгцээ, шаардлага, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй, хяналт-үнэлгээ, тайлагнах нэгдсэн тогтолцоогүй явж ирснээс шалтгаалсан байх талтай юм.

[2]Мөн тэнд.

Олон улсын туршлагаас үзэхэд[3] хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга, механизмыг хуульчлан зохицуулсан эрх зүйн акт төдийлөн байхгүй боловч урт хугацааны бодлогын баримт бичиг, стратеги, хөтөлбөрүүд боловсруулан батлуулж, хэрэгжүүлж байна. Зарим орны хувьд даацтай хөгжлийн баримт бичиг (улс орны хөгжлийг тодорхойлох бус хүрээлэн байгаа орчинд ээлтэйгээр тодорхой нэг зорилт дэвшүүлсэн баримт бичиг) болон үндэсний хөгжлийн үзэл баримтлалыг батлан, аль алиныг нь дагаж мөрдөж байна. Үндэсний хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгүүд болон даацтай хөгжлийн баримт бичгийн гол ялгаа нь:

- Хамрах хугацаа[4];
- Хөгжлийн нөөц бололцоог үнэлсэн байдал;
- Хөгжлийн нөөц бололцоонд тулгуурлан хөгжлийн гарц, чиглэлүүдийг тодорхойлж, боломжит хувилбаруудыг үнэлж, сонгох байдлаараа ялгаатай.

Даацтай хөгжлийн баримт бичгийн гол зорилго нь улс орныг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлох бус хүрээлэн буй орчинд ээлтэй байх стандартыг хөгжлийн бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх явцад мөрдөх, үндэсний хөгжлийн урт хугацааны бодлогын суурийг тодорхойлох зорилготой байдаг.

Бодлогын төлөвлөлт, тайлагнах нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох, удирдлага зохион байгуулалтын бүтцийг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчний чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллага хоорондын мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцлагын тогтолцоог бий болгох нь өнөөгийн бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой тулгамдсан асуудлууд болоод байна.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн төсөлд төрөөс батлан гаргах бодлогын баримт бичгүүдийн нэр төрлийг хуульчлан зааж, эдгээр бодлогын баримт бичгүүдийг хэрхэн боловсруулах, хэрхэн батлах, хэрэгжилтийн хяналт шинжилгээ-үнэлгээг хэрхэн хийхтэй холбоотой харилцааг зохицуулахаар хуульчилсан байна. Хуулийн төслийн танилцуулга ба төсөлд тусгасан зохицуулалтуудыг авч үзвэл:

- **Үндэсний хөгжлийн урт хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулахдаа иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод болон улс төрийн намуудын оролцоог хангасан байх;**
    - Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулах;
    - Хуулийн төслийн 13.2-т Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дэргэдээ Бодлогын судалгааны хүрээлэнг ажиллуулж болохоор тусгажээ.

  Хэдийгээр Үндэсний хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулахаар тусгасан нь сайшаалтай боловч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статус, эрхлэх үйл ажиллагааны талаар хуулийн төсөлд тусгаагүй байна.

[3]Мөн тэнд

[4]Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь 15-30 жилийн хугацааг хамарч байхаар боловсруулдаг. Даацтай хөгжлийн баримт бичгүүд нь дунд хугацаанд буюу 10 хүртлэх жилийг хамардаг боловч зарим орнууд 10-аас 25 жилийн хугацаанд төлөвлөсөн нь бий. Энэ тохиолдолд даацтай хөгжлийн баримт бичигт хөгжлийн алсын хараа тусгасан байдаг. Гэхдээ энэ нь ихэнх тохиолдолд эдийн засгийн нөөц бололцоог бий болгож, даацтай хөгжих суурийг бий болгосон байх төлөвтэй байна.

- **Салбарын, салбар хоорондын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийг хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт үндэслэн боловсруулах;**
    - Хуулийн төслийн 13.1-т: бодлогын баримт бичгийг боловсруулахад тавигдах шаардлагыг тусгасан;
    - Хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт: Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах процессыг хуульчилсан.
    - Хуулийн төсөлд тусгаснаар дараах 10 бодлогын баримт бичиг байхаар тусгасан байна. Үүнд:

    1/ Монгол Улсын Хөгжлийн үзэл баримтлал;
    2/ Төрөөс баримтлах бодлого;
    3/ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
    4/ Үндэсний хөтөлбөр;
    5/ Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр;
    6/ Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө;
    7/ Бүсчилсэн хөгжлийн бодлого;
    8/ Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт;
    9/ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөр;
    10/ Аймаг, нийслэл, сум дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө

Хуулийн төсөлд салбарын болон салбар хоорондын бодлогын баримт бичгийг хэрхэн урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулах талаар тодорхой зохицуулсан зохицуулалт байхгүй байна.

- **Хөгжлийн бодлогын баримт бичиг нь улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдан төсөв санхүүгийн эх үүсвэртэйгээ уялдсанаар хэрэгждэг байх;**
    - Хуулийн төслийн 15.1-т Бодлогын баримт бичгийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлэхээр хуульчилсан байна. Үүнд:

    1/ улсын болон орон нутгийн төсөв;
    2/ гадаадын зээл, тусламж;
    3/ гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
    4/ Засгийн газрын гадаад үнэт цаас;
    5/ Концессын гэрээ;
    6/ Засгийн газрын баталгаа;
    7/ бусад эх үүсвэр болно.

    Харин хуулийн төслийн 13.1-т заасан Бодлогын баримт бичгийг боловсруулахад тавигдах шаардлагад санхүүжилтийн талаарх зохицуулалтыг тусгаагүй байна.

- **Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлох, үндэсний, салбарын, салбар хоорондын болон орон нутгийн хөгжлийн бодлогуудын уялдааг хангах, хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааг ерөнхий чиг үүргийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулдаг байх;**

Хуулийн төслийн 2 дугаар бүлэгт Хөгжлийн бодлого төлөвлөлттэй холбоотой төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тусгасан байх боловч Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, харъяалал зэрэг нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй байна.

Энэхүү хууль батлагдсанаар Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлттэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдэх ба хөгжлийн бодлогын баримт бичгүүд цэгцтэй, уялдаа холбоотой болж бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хяналт үнэлгээг тайлагнах нэгдсэн тогтолцоо бүрдэх, бодлогын уялдаа холбоог хангах зэрэг ач холбогдолтой байна.

Хоёр. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БУСАД ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хөгжлийг ойлгох ойлголтын ялгаанаас үүдэн улс орнууд хөгжлийн бодлогоо харилцан адилгүй төлөвлөж, тодорхойлохоос гадна улс орон бүр өөрийн орны нийгэм улс төр, эдийн засгийн онцлог байдал, уламжлал, түүх соёл, гадаад дотоод нөхцөл байдалд нийцүүлэн хөгжлийн бодлогоо боловсруулдаг байна.

Буурай хөгжилтэй улс орнуудын хувьд хуримтлал бий болгох чадавхаа зөв бүрдүүлсэн бусад орнуудын хүрсэн түвшин болон олон улсын стандартаар баримжаалж хөгжлийн бодлогоо тодорхойлох ерөнхий хандлагатай байдаг бөгөөд ийм арга замаар тодорхойлсон хөгжлийн бодлого нь эдийн засгийн хүчин чадлыг богино хугацаанд үр ашиггүй, үр өгөөж багатай салбарт зарцуулахад хүргэдэг бөгөөд үйлдвэрлэл, эдийн засгийн төрөлжилт, бүтээх чадвар бий болдоггүй сул талтай байдаг байна.

Үндэсний хөгжлийн хүрээлэнгээс 2014 онд хийсэн “Хөгжлийн урт хугацааны бодлогын харьцуулсан шинжилгээ”-нд дурдсанаар аливаа улс орон бүр хөгжлийнхөө үйл явцыг төсөөлөхдөө аль ч үе шатанд дотоод нөөц бололцоондоо тулгуурласан байхаар тооцож, бодлогоо тодорхойлсон байхаас гадна улс орнуудын хөгжлийн бодлогоо тодорхойлохдоо баримталсан гол гол үзэл баримтлалуудыг тоймлон гаргасан байна. Үүнд:

- Хөгжлийн хамгийн чухал нөөц нь үндэсний соёл, хүмүүний хөгжил бүтээх чадавх гэж үзэх хандлага;
- Технологийн хуримтлал, түүний хүрсэн түвшинг хөгжлийн гол эх сурвалж гэж үзэх хандлага;
- Байгалийн нөөц баялаг, түүний үр өгөөжтэй ашиглалт, боловсруулалт нь хөгжлийн гол эх сурвалж гэж үзэх хандлага;
- Хөрөнгийн хуримтлал, санхүүгийн давуу тал нь хөгжлийн гол эх сурвалж гэж үзэх хандлага.

Мөн хөгжлийн боломж бололцоогоо зөвөөр харж чадсан улс орнууд дотоод нөөц бололцоогоо судалгаанд суурилан нарийн тодорхойлж, хөгжлөөр доогуур байгаа салбаруудын түвшинг ахиулан, хөгжих нөөц боломж сайтай салбаруудыг судалгаа шинжилгээний үндсэн дээр улам хөгжүүлэх замаар дэлхийд тэргүүлэх салбар болгоход анхаарч бодлогоо боловсруулдаг байна.[5]

Бусад орнуудын туршлагаас харахад хөгжлийн гол тэргүүлэх чиглэлээр цөөн тооны чухал салбаруудыг тооцоо судалгааны үндсэн дээр сонгож, түүнийг хэрэгжүүлэхэд бусад салбартай уялдаа бүхий цөөн тооны зорилтуудыг дэвшүүлэх нь зүйтэй гэж үзжээ.[6] Тухайлбал бусад орнуудын урт хугацааны бодлогын баримт бичгүүдийн зорилтууд нь тодорхой эрэмбэ дараалалтай, өөр хоорондоо уялдаа бүхий ихэвчлэн 5-9 бодлогын гол чиглэлийг тодорхойлсон байдаг бол харин манай улсын Үндэсний хөгжлийн цогц бодлогын стратегийн зорилт, дэд зорилтууд нь эрэмбэгүй, өөр хоорондоо харилцан уялдаагүйгээс гадна дээрх тооноос стратегийн зорилт 15 дахин, дэд зорилт нь 12 дахин олон байна.

[5]Үндэсний хөгжлийн хүрээлэн. Хөгжлийн урт хугацааны бодлогын харьцуулсан шинжилгээ. Уб., 2014. 45 дахь тал.
[6]Мөн тэнд.

Хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийн тэргүүлэх чиглэл, зорилтуудыг томьёолохдоо ач холбогдол, салбар хоорондын уялдааг хангасан байдлаар нь эрэмбэлж, дэс дараалалтайгаар төлөвлөх нь бодлого үр дүнтэй хэрэгжихэд нөлөөлнө. Ингэхдээ томоохон стратегийн зорилтыг нэн тэргүүнд заавал биелүүлэх нөхцөлтэйгөөр томьёолох нь бусад салбарын дэд зорилтууд аяндаа биелэх нөхцөлийг бүрдүүлдэг байна.[7]

Хөгжлөөрөө тэргүүлэгч, хөгжлийн бодлого төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлсэн орнуудын арга, туршлагын талаар УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтсээс 2013 онд дэлгэрэнгүй судалгааг гүйцэтгэсэн. Хөгжлийн бодлого төлөвлөлтийг амжилттай хэрэгжүүлж байгаа Ботсвана, Их Британи, Малайз, ОХУ зэрэг орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтын талаар авч үзэхдээ Улсын Их Хуралд өргөн баригдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийн төслийн агуулгын хүрээнд дараах асуудлуудаар судаллаа. Үүнд:

2.1 Тухайн улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг зохицуулж буй үндсэн бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж;
2.2 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа баримтлах зарчим, тавигдах шаардлага;
2.3 Хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын эрх, үүрэг;
2.4 Бодлогын баримт бичгийг санхүүжүүлэх эх үүсвэр;
2.5 Бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах үе шат, процесс;
2.6 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо зэрэг асуудлуудыг авч үзлээ.

Судлагдсан орнуудын хувьд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тусгайлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт бүхий хууль тогтоомж байхгүй байна.

2.1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг зохицуулж буй үндсэн бодлогы*н баримт бичиг, хууль, тогтоомж*

ОХУ

ОХУ-ын хувьд 1920 оноос хойш стратеги төлөвлөгөөг боловсруулж ирсэн. Тус улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зохицуулж буй үндсэн баримт бичиг нь 2009 оны 536 тоот Ерөнхийлөгчийн зарлиг[8]-аар баталсан “ОХУ-ын стратеги төлөвлөлтийн үндсийн тухай”, 2008 онд “ОХУ-ын нийгэм-эдийн засгийг 2020 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал” 2012 онд “ОХУ-ын нүүрсний аж үйлдвэрийг 2030 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” 2014 оны “ОХУ-ын стратеги төлөвлөлтийн тухай хууль” бөгөөд эдгээр бодлогын баримт бичигтэй уялдан дэд, дунд хугацааны зэрэг холбогдох баримт бичгүүдийг батлан гаргасан байдаг.

Ботсвана Улс

Ботсвана улсын хувьд Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг 1996 оноос эхлэн боловсруулж эхэлсэн бөгөөд бүхий л салбарыг хамарсан 20 жилийн хугацаатай цогц төлөвлөгөөг баталдаг байна. Төлөвлөгөө батлагдсанаас хойш, жил бүр тухайн жилийн үр дүн, алдаа оноогоо хянан шинжилж, төлөвлөгөөгөө улам боловсронгуй болгож, уг төлөвлөгөөгөө тухайн үеийн бодит байдалтай нийцүүлэн, хэрэгжих боломжтой бодлого болгож чаддаг байна.

[7]Мөн тэнд.
[8]Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 “Об Основах стратегического планирования в РФ”.

1996 онд Ерөнхийлөгчийн санаачилгаар Үндэсний хөгжлийн цогц бодлогын алсын хараг боловсруулах зорилготой “Ажлын хэсэг” (Task group)-ыг байгуулсан бөгөөд энэхүү ажлын хэсэгт Засгийн газар, иргэдийн төлөөлөгч, хувийн хэвшлийн төлөөлөгчдөөс бүрдсэн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байсан бол дараа жил нь 31 гишүүнтэй болон өргөжиж, үндэсний хөгжлийн төлөвлөгөөг хамтран боловсруулсан байна.

Малайз Улс

Тус улсын Засгийн газар хөгжлийн төлөвлөлтийг 1950-иад оноос эхлэн боловсруулж ирсэн бөгөөд хөгжлийн бодлого төлөвлөлтийг урт, дунд, богино хугацаагаар төлөвлөдөг бөгөөд урт хугацааны төлөвлөлт /1990 онд баталсан Хэтийн баримт бичиг - Vision 2020/ нь 30 жилийн хугацааг хамарсан үндсэн бодлогын баримт бичиг байх бөгөөд энэхүү урт хугацааны төлөвлөлтийн баримт бичигт тулгуурлан дунд, богино хугацааны төлөвлөлтүүдээ хэрэгжүүлдэг байна.

Ингэснээрээ тус улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдаа холбоо сайтай байх бөгөөд дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх төлөвлөлтийг тухай бүр засаж сайжруулах, тухайн үе дэх нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан хэрэгжүүлэх боломжтойгоор засаж сайжруулан төлөвлөдөг байна.

Их Британи

Тус улсын төлөвлөлтийн бодлого болон эрх зүйн зохицуулалт бүхий баримт бичгийн хувьд дараах байдлаар авч үздэг байна.
Төлөвлөлтийн хууль тогтоомжийн хүрээнд:

- Хот, орон нутгийн төлөвлөлтийн хууль /1990 он/,
- Төлөвлөлт, төлөвлөсөн газрыг худалдаж авах тухай хууль /2004 он/,
- Орон нутгийн ашиг сонирхлын тухай хууль /2011 он/,
- Төлөвлөлтийн тухай хууль /2008 он/.

2.2 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа баримт*лах зарчим, тавигдах шаардлага*

ОХУ

Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд дараах үндсэн зарчмуудыг баримталдаг байна.

- ОХУ-ын стратеги төлөвлөлт, нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх арга хэмжээ нь үндэсний аюулгүй байдлыг хангах асуудалтай харилцан уялдаатай байх;
- Өмнөх стратеги төлөвлөлтийн зарчмуудыг харгалзан үзэж, дараагийн төлөвлөлтийг боловсруулах зарчмыг мөрдөх;
- Үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгын хүрээнд ОХУ-ын төрийн байгууллагуудын бүрэн эрх болон тэдгээрийн үйл ажиллагааны зохицуулалтыг зааглах;
- Тогтвортой хөгжилтэй холбоотой урт хугацааны шийдвэрүүд нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүдтэй нийцсэн байх;
- Үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх болон эдийн засаг, соёл, оюуны хөгжлийг эрчимжүүлэх арга хэмжээг цаг үеэ олж хэрэгжүүлэх;
- Хувь хүн, нийгэм, улс орноо зохистой хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад үндэсний стратеги чиглэлүүдэд цаг үеэ олж тодотгол хийх;
- Тогтвортой хөгжүүлэх болон үндэсний аюулгүй байдлыг хангахад материаллаг, санхүү, боловсон хүчин, шинжлэх ухаан-технологи, мэдээлэл болон бусад нөөцийг төвлөрүүлэх;

- Хөгжлийн стратеги төлөвлөлтийн зохион байгуулалт нь нэгдмэл, бүрэн бүтэн байдал, бүрэн эрхийг зааглах, залгамжлах чанар, тасралтгүй байх, стратеги төлөвлөлтийн үр ашиг, стратеги төлөвлөлтөд оролцогчдын хариуцлага, үр дүн, тэдгээрийн нээлттэй ил тод байдал, бодит байдал, нөөцийн хангамж, зорилгодоо нийцэх зарчмууд дээр үндэслэгдэж байна.
- Стратеги төлөвлөлтийн үр дүн үр ашгийн зарчим нь хамгийн бага зардлаар төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд оршиж байна.
- Ил тод байх зарчим нь төрийн байгууллагын нууцад хамаарагдахгүйгээр олон нийтэд ил тод байж, олон нийтийн оролцоог хангана.

2.3 *Хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагын эрх, үүрэг*

ОХУ

Тус улсын хувьд Стратеги төлөвлөлтийн ерөнхий удирдлагыг ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд тус улсын Ерөнхийлөгч хэрэгжүүлнэ. Харин Аюулгүй байдлын зөвлөл нь өөрийн бүрэн эрх, чиг үүрэгт нийцүүлэн стратеги төлөвлөлтийг зохицуулахын зэрэгцээ холбогдох баримт бичгийн улсын дотоод, гадаад бодлогын асуудалд шинжилгээ хийдэг байна.

Тус улсын хөгжлийн түвшин, үндэсний аюулгүй байдалд тавих хяналтыг Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан, ОХУ-ын субъектүүдын захиргааны улсын байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, үндэсний аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг судалсны үндсэн дээр хийдэг байна.

Мөн ОХУ-ын нийгэм-эдийн засгийн хөгжлийн прогноз болон хөтөлбөрийн тухай Холбооны хуульд[9] зааснаар ОХУ-ын Засгийн газар, Төв банк хамтран тус улсын эдийн засгийн нөхцөл байдалд хяналт тавина. Стратеги төлөвлөлтийн хүрээнд ОХУ-ын субъектүүдийн төрийн эрх барих байгууллагын болон гүйцэтгэх засаглалын холбооны байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулах журмыг тогтооно. Мөн стратеги төлөвлөлтийн хүрээнд ОХУ-ын төрийн барих байгууллагуудын бүрэн эрхэд дараах зүйлүүд хамаарагдаж байна.

- Стратеги төлөвлөлтийн системийн ажиллагаа болон зохион байгуулалтын зарчмыг тогтоон хэрэгжүүлэх;
- Стратеги төлөвлөлтийн дарааллын журам тогтоох;
- Нийгэм-эдийн засгийн бодлого, ОХУ-ын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилго, түүнчлэн зорилгодоо хүрэх арга зам, нөөц бололцооны эх үүсвэрүүдийн тооцоолол, давуу сул талуудыг тодорхойлох;
- Стратеги төлөвлөлтийн агуулга, түүнийг боловсруулах журам, хянан засварлах, хэлэлцүүлэн батлахад тавигдах нийтлэг шаардлагуудыг тогтоох;
- Стратеги төлөвлөлтийн талаар ОХУ-ын холбоо болон субъектийн түвшинд боловсруулсан стратеги төлөвлөлтийн талаарх баримт бичгүүдийн уялдаа холбоог хангах;
- Стратеги төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад арга зүйгээр хангах;
- Төрийн эрх барих холбооны байгууллагаас баталсан стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд хяналт тавих, дүгнэлт өгөх гэх мэт.

[9]ФЗ от 20 июля 1995 г. №115-ФЗ “О государственном прогнозировании и программах социально-экономического развития РФ”.

Малайз Улс

Тус улсын Ерөнхий сайдын дэргэд хөгжлийн төлөвлөлт боловсруулах, салбар хоорондын төлөвлөлт, хяналтын механизмыг бий болгох чиг үүрэг бүхий “Эдийн засгийн төлөвлөлтийн нэгж” - ажлын албыг байгуулан ажилладаг байна.

Малайзад эдийн засаг, нийгмийн асуудлаар шийдвэр гаргах хамгийн дээд түвшний байгууллага бол “Үндэсний төлөвлөлтийн зөвлөл” бөгөөд энэ нь Засгийн газарт эдийн засгийн чиг үүргийг гүйцэтгэхэд дараах байдлаар оролцоно. Үүнд:

- Үндэсний төлөвлөлтийн зөвлөлийн гишүүд нь санхүү, олон улсын худалдаа, үйлдвэрлэл, дотоод худалдаа, үйлдвэрлэлийн хөгжил, хөдөө аж ахуй зэрэг эдийн засгийн гол салбарын яамдын сайд нар байна.
- Үндэсний төлөвлөлтийн зөвлөлөөс гадна хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн асуудлыг хариуцан, салбарын бусад яамдыг хамарсан Үндэсний хөгжлийн зөвлөл, аюулгүй байдлыг хариуцсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ажиллах бөгөөд эдгээр гурван зөвлөлийн үйл ажиллагааг Ерөнхий сайд удирддаг байна.



Их Британи

1973 онд Европын холбооны гишүүнээр элссэн бөгөөд орон нутгийн төлөвлөлтийн байгууллага[10]-ыг эс тооцвол төлөвлөлтийн чиг үүрэг эрхэлсэн тусгай институци байхгүй бөгөөд тус улсын төлөвлөлтийн бодлогын асуудлыг Төвлөрлийг сааруулах, хотуудын асуудал эрхэлсэн сайд, парламентын гишүүн тус тус эрхэлсэн асуудлын хүрээнд хариуцдаг байна.

[10]Planning Inspectorate.

Мөн түүнчлэн Их Британи Улсын Засгийн газрын Тогтвортой хөгжлийн стратеги буюу Ирээдүйг баталгаажуулахуй (Securing the Future) баримт бичгийг 2005 онд батлан гаргасан байна.

2.4 Бодлогын баримт бичгийн төрөл, санхүүжүүлэх эх үүсвэр

ОХУ

Стратеги төлөвлөлтийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтод нийцсэн прогноз, үзэл баримтлалын баримт бичгүүд (үзэл баримтлал, сургааль, стратеги, үндэс), хөтөлбөрүүд, төлөвлөгөө болон зохицуулалтын баримт бичгүүд, эрх зүйн акт, мөн мэдээлэл, судалгаа шинжилгээ, лавлагаа зэрэг туслах баримт бичгүүдийг боловсруулдаг.

Холбооны улсын түвшинд стратеги төлөвлөлтийг урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хэд хэдэн үндсэн баримт бичгүүд байна. Үүнд:

1) Үндэсний аюулгүй байдлыг хангах стратеги,
2) Шинжлэх ухаан-технологийг хөгжүүлэх урт хугацааны прогноз,
3) Нийгэм - эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны прогноз,
4) Нийгэм - эдийн засгийг хөгжүүлэх урт хугацааны үзэл баримтлал,
5) Салбаруудыг хөгжүүлэх урт хугацааны баримт бичгүүд,
6) Холбооны төсвийн урт хугацааны стратеги,
7) Холбооны зорилтод хөтөлбөрүүд,
8) Газар нутгийн төлөвлөлтийн схем,
9) Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл,
10) Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх дунд хугацааны төслүүд,
11) Нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх дунд хугацааны прогноз,
12) Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төслүүдийн үр дүн, явцын талаарх жилийн төлөвлөгөө.

Малайз Улс

Урт хугацааны төлөвлөлт:

Ихэвчлэн 20-30 жилийн хугацааг хамран төлөвлөж байна. Энэхүү баримт бичгийн хувьд үндэсний урт хугацааны хөгжлийн хүсэл эрмэлзлийг тусгаж, нийт үндэсний хөгжлийн чармайлтыг илэрхийлсэн байна.

- Хэтийн баримт бичиг /Vision/ 2020, 1991-2020,
- Хэтийн төлөвлөгөөний эхний тойм,[11] /First Outline Perspective Plan (OPP1)/ 1971-1990,
- Хэтийн төлөвлөгөөний хоёр дахь тойм,[12] /Second Outline Perspective Plan (OPP2), 1991-2000,
- Хэтийн төлөвлөгөөний гурав дахь тойм,[13] /Third Outline Perspective Plan (OPP3) /2001-2010,
- Шинэ эдийн засгийн загвар /New Economic Model, 2010-2020.

Дунд хугацааны төлөвлөлт:

Хэтийн төлөвлөгөөний тоймыг хэрэгжүүлэх дараагийн үе шат болох дунд хугацааны төлөвлөлт нь 5 жилийн хугацаатайгаар хийгдэнэ. Энэ нь макро-эдийн засгийн зорилт, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэмжээ, хуваарилалтыг тодорхойлдог байна.

[11] www.adbi.org/files/2010.07.14.cpp.ps2.1.idris.mdg.malaysian.dev.experience.pdf
[12] Мөн тэнд.
[13] http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/APCITY/UNPAN003664.pdf

Таван жилийн төлөвлөлтийн мөчлөгийн дундуур таван жилийн төлөвлөгөөний дунд хугацааны хэлэлцүүлэг хийдэг. Энэ хэлэлцүүлгээр төлөвлөгөөний тавьсан зорилго, зорилтын биелэлт, зарим тохиолдолд шаардлагатай гэж үзвэл макро-эдийн засаг, салбарын стратеги төлөвлөлтөд нэмэлт өөрчлөлт оруулж болдог байна.

- Таван жилийн хөгжлийн төлөвлөгөө /Five-year development plans, such as the Tenth Malaysia Plan[14]/ (2010-2015)
- Таван жилийн төлөвлөгөөний дунд хугацааны хэлэлцүүлэг. /Mid-term review (MTR) of the five-year Plans[15]/

Богино хугацааны төлөвлөлт:

Богино хугацааны төлөвлөлтийг жил бүрийн төсвөөр хийх бөгөөд тухайн жилийн төсвийн дагуу Сангийн яам боловсруулж, хэрэгжүүлнэ.



- Жил бүрийн төсөв

Их Британи[16]

Тус улсын хувьд урт хугацааны төлөвлөлтийн үндсэн баримт бичиг нь 2011 онд батлагдсан Үндэсний Төлөвлөлтийн Бодлогын хүрээ бөгөөд энэхүү бодлогын баримт бичиг нь дараах үндсэн 3 чиглэлтэй байна.

1/ Төлөвлөлтийн бодлого /planning policy statements/,
2/ Эрдэс баялгийн бодлого /minerals policy statements/,
3/ Үндэсний бодлого /National policy statements/.

2.5 Бодлогын баримт бичгийг боловсруулах, батлах үе шат, процесс

ОХУ

Ерөнхийлөгчийн баталсан ОХУ-ын стратеги төлөвлөлтийн үндэс[17]-д зааснаар Стратеги төлөвлөлтийн баримт бичгүүдийг Ерөнхийлөгчийн Холбооны хуралд илгээсэн илгээлт ба төсвийн тухай илгээлт, мөн гүйцэтгэх засаглалын холбооны байгууллагууд болон ОХУ-ын субъектүүдын төрийн байгууллагуудын бэлтгэсэн албан ёсны статистик, мэдээлэл,

[14]www.tijoss.com/TIJOSS%2011th%20Volume/zaleha6.pdf
[15]http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/APCITY/UNPAN003664.pdf
[16]Planning Policy Statement, The Government Objectives for the Planning System, The United Kingdom, 2005.
[17]Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 “Об Основах стратегического планирования в РФ”.

шинжилгээ, шинжлэх ухааны судалгаа /үүнд иргэдээс авсан санал асуулга хамаарна/, дотоод, гадаадын стратеги төлөвлөлтийн туршлагад хийсэн шинжилгээ, бусад баримт бичигт нийцүүлж боловсруулна.

Ерөнхийлөгчийн Холбооны хуралд илгээсэн илгээлт ба төсвийн тухай илгээлт нь тус улсын тогтвортой хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тухайн үеийн болон стратеги тулгуур зорилтыг тусгасан байдаг.

Ботсвана Улс

Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа нарийн шат дамжлагтайгаар холбогдох бүх байгууллагуудыг оролцуулан, улс төрийн нам эвслүүдийн саналыг тусган, хариуцсан яам нэгтгэж, Үндэсний чуулганаар дараах байдлаар батлуулдаг.

- Санхүү болон Хөгжлийн Төлөвлөгөөний Яам (MFDP) бодлогын гол зорилтуудын хураангуй баримт бичгийг бэлтгэн Эдийн Засгийн Зөвлөлд хүргүүлнэ.
- Эдийн Засгийн Зөвлөл бодлогын хураангуй баримт бичгийг хянаж, холбогдох салбарын яамдад дэлгэрэнгүй зааварчилгаа өгнө. Зааварчилгаанд орон нутгийн засаг захиргаа, иргэдийн нийгэмлэг болон холбоо, байгууллага, мөн хувийн хэвшлүүдтэй зөвлөлдөх процессыг тусгасан байна. Энэхүү удирдамжийг холбогдох яамдад хүргүүлнэ.
- Яамд тус бүр төсөвтөө тулгуурлан, өөрийн яамны тэргүүлэх зорилт болон ажлыг тодорхойлсон баримт бичгийг Эдийн Засгийн Зөвлөлд буцаан хүргүүлнэ.
- Засгийн газар “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө 9” буюу өмнөх жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хувийн хэвшил, төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, академик институц болон “Алсын хараа зөвлөл”–өөс санал авдаг.
- Энэхүү саналыг Эдийн Засгийн Зөвлөл, яамдын нарийн бичиг, Төв банкны төлөөлөгчид бодлогын баримт бичгийг тусган Санхүү болон Хөгжлийн Төлөвлөгөөний Яам (MFDP) –д өргөн барина.
- Санхүү болон Хөгжлийн Төлөвлөгөөний Яам нь Парламенттай зөвшилцөж, улс төрийн нам, эвслийн санал хүсэлтийг тусган, “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө 10” буюу дараа жилийн төлөвлөгөөний төслийг бэлтгэн “Танхим” (cabinet) – аар хянуулж, батлуулна.
- Танхимаар батлагдсан Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг эцсийн байдлаар Үндэсний Чуулган баталснаар уг төлөвлөгөө хүчин төгөлдөр болно.

Малайз Улс

Хөтөлбөр, бодлогын баримт бичгийг боловсруулахдаа дараах үе шаттай байна.

- Хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөгөөг Засгийн газрын зүгээс өнгөрсөн 5 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан дараагийн 5 жилийн хөгжлийн стратеги хөтөлбөрийн төслийг яам, төрийн эрх бүхий байгууллагуудад тойм хэлэлцүүлэг хэлбэрээр сонгон шалгаруулалт зарлана.
- Сонгон шалгаруулалтад тэнцсэн төсөл, хөтөлбөрийн төслийг EPU буюу Үндэсний хөгжлийн хөтөлбөрийг төлөвлөх хороогоор хэлэлцүүлэн баталдаг байна.
- Хэлэлцэж, санал болгож буй хөгжлийн хөтөлбөрийн зардал тооцоо нь ойрын 5 жилийн төлөвлөгөөтэй маш сайн уялдсан байдаг.
- Малайз Улсын яамдууд болон агентлагууд нь хөгжлийн хөтөлбөрийн төсөл болон хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хянан шалгадаг. Нарийн шалгууруар явагдах зарим сонгон шалгаруулалт нь бүс нутгийн тэнцвэртэй байдал, ядуурлыг бууруулахад чиглэсэн, нийгмийн үүрэг хариуцлагыг ухамсарласан, зэрэг тодорхой алхмуудад чиглэсэн байх ёстой.

Харин дэд бүтцийн төслийн хувьд, энэ хөгжил нь мастер төлөвлөгөөний дагуу төслийн урьдчилсан байдлыг тодорхойлоход чиглэсэн байдаг байна.

2.6 Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ, үнэлгээ

Аливаа хяналт-шинжилгээний тогтолцоонд хариуцах байгууллага, удирдлага, байнгын ажиллагаатай байх, найдвартай байх гэсэн 4 бүрэлдэхүүн хэсэг зайлшгүй байх шаардлагатай бөгөөд бодлого, төсөл хөтөлбөрийг хэн, хэрхэн, хаана удирдах нь тогтвортой ажиллагаанд ихээхэн чухал юм. Хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоо байнгын ажиллагаатай байх нь уг тогтолцоо суларч муудах, задран унахаас сэргийлэхэд чухал байдаг байна.

Малайз Улс[18]

Малайз Улсын хувьд урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлыг муж хооронд болон хэлтэс нэгж хооронд зохицуулах, төслийн хэрэгжилтийг хянах ажлыг Хэрэгжилт Зохицуулалтын Алба (ХЗА) буюу Implementation and Coordination Unit (ICU) гүйцэтгэдэг байна. Ингэснээр Засгийн газрын үйлчлэх механизмууд хүчин чадлын хувьд хэр боломжтой байгаа талаарх мэдээллээр хангагдах болон эдийн засаг үүнд нь зохицож ажиллаж байгаа эсэх, нийгэм, эдийн засагт нөлөөлж буй нөлөөллийг тооцон судлах зэрэг ач холбогдолтой юм.

Хэрэгжилт зохицуулалтын алба нь нөлөөллийг судалснаар Засгийн газар хэрэгжүүлж байгаа төсөл болон хөтөлбөрийн стратегийн үр өгөөжийг тооцоолж нийгэм-эдийн засгийн зорилтод түлхүү анхаарах ингэснээр цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөв арга барил олоход асар их тустай байдаг байна.

Түүнчлэн яамд болон хэлтэс газруудаас хэрэгжилтийн талаар гаргасан саналыг ХЗА хүлээн авч цаашдын төлөвлөлтийг хэрэгжүүлэх арга ажиллагаа болон стратеги боловсруулахад хэрэглэдэг.

Өнөөгийн байдлаар Малайз Улсын хувьд /Мальти Медиа Супер Корридор Multimedia Super Corridor endeavour/ хүчин чармайлтын хүрээнд хэрэгжиж байгаа долоон төрлийн туг хэмээх хөтөлбөрийн хүрээнд Цахим Засаглал (е-засаглал) төсөл нь олон нийтийн үйлчилгээг мэдээллийн технологийн тусламжтайгаар хангахаар зохицуулагдсан байна. Е-засаглал төслийн хүрээн дэх анхдагч програм нь Төслийг Хянах Систем II (ТХСII) юм. Энэхүү систем нь хөгжлийн төслүүдийг 5 жил хэрэгжих төслийн хугацаанд хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан хянах болно. ТХСII нь хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бүх яамд болон Засгийн газрын холбогдох хэлтэс албадтай онлайнаар холбоотой ажиллаж, төслийн талаарх бүх мэдээллээр тэднийг тасралтгүй хангаж ажиллах ёстой. ТХСII–ийг Ерөнхий сайд 2001 онд эхлүүлснээс хойш бүх яамд болон агентлагт хэрэглэгдэж байгаа юм байна.

Ботсвана Улс

Боствани Улс нь хөгжлийн бодлого, төлөвлөлт, төсөл, стратеги зорилтуудыг урт удаан хугацаанд хэрэгжүүлэхэд хяналт, шалгалтын зохистой тогтолцоог бий болгох үүднээс доорх нэгжүүдийг бий болгосон байна.

[18]www.epu.gov.my/c/document_library/

- Бодлого ба төслийн хэрэгжилтийг хянах үүднээс нарийн бичгүүдийг сонгон ажиллуулдаг Төслийн Хэрэгжилтийн Байнгын Хороо /Standing Committee on Project Implementation/ (SCOPI) байгуулж байсан байна.
- 2001 онд Санхүү ба Хөгжлийн Төлөвлөлтийн Яамны бүтцэд Төслийн Хяналтын Нэгж /Project Monitoring Unit/-ийг байгуулсан.
- 2004 онд Санхүү ба Хөгжлийн Төлөвлөлтийн Яам нь Төслийн Хяналтын Тогтолцоог хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт үнэлгээгээр дутагдалтай талууд нь:

- Зарим бодлого, хөтөлбөр, төслийн зорилтот бүлэг ба гүйцэтгэлийн үзүүлэлтүүд нь тодорхой бус;
- Зарим бодлого, хөтөлбөр, төслийн гүйцэтгэлийн тухай мэдээлэл өгөгдлүүд дутмаг;
- Бодлогууд нь өөр хоорондоо зөрчилдсөн зорилтуудтай;
- Хяналт ба Үнэлгээний системүүд нь өөр хоорондоо уялдаа холбоо байхгүй (мэдээллийн солилцоо байхгүй) Хяналт ба үнэлгээнд зориулсан бүтэц нь үндсэндээ зохистой бус.
- Бодлого ба стратеги зорилтууд нь яагаад дэвшүүлсэн зорилтууддаа хүрч чадахгүй байгаа талаар урьдчилан судалж дэвшүүлсэн зорилтууд нь нэгдмэл биш гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Эдгээр асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэх үүднээс Засгийн Газар нь 2007 оны 5-р сард "Засгийн Газрын Хэрэгжилт Хамтын Ажиллагааны Алба"-/Government Implementation Coordination Office/ -ыг (GICO) үүсгэн байгуулжээ.

Ийнхүү "Засгийн Газрын Хэрэгжилт Зохицуулалтын Алба"-(GICO)-ыг үүсгэн байгуулах нь "Бизнес ба Эдийн Засгийн Зөвлөлийн Хурлын" (BEAC) санал болгосон чухал арга хэмжээ байсан байна.

Энэхүү зөвлөлийн хурал нь 2005 онд Засгийн Газарт эдийн засгийн бодит өсөлт хөгжилд хүрэх үүднээс хурдацтай эдийн засгийн олон талт зорилтыг биелүүлэхэд нь туслах зорилгоор байгуулагдсан байна. Энэ байгууллага нь өөрийн орны бодлого, төслийн хэрэгжилтийг судлан үзээд, «Ботсвана улсын гол алдааны нэг бол том ч бай, жижиг ч бай ялгаагүй олон төсөл хөтөлбөрүүд төлөвлөгдсөн хугацаандаа дуусдаггүй, ямагт сунжирдаг, төлөвлөлт ба хэрэгжилт нь муу, ямагт илүү өртөгтэй байх эсвэл хүлээн зөвшөөрөгдөхүйц стандартаас доогуур түвшинд болдог. Төслийн менежмент ба гүйцэтгэлийн дутагдалтай талууд нь төслийн менежментийн алдаатай байдал ба гүйцэтгэх чадвар сул байгаатай холбоотой гэж дүгнэсэн байна. Үүнийг шийдвэрлэх үүднээс тус зөвлөл нь Ерөнхийлөгчийн албаны дэргэд Хэрэгжилт Зохицуулалтын Нэгж байгуулахыг санал болгосон байдаг байна.

Засгийн Газрын Хэрэгжилт Зохицуулалтын Алба»-ны бүрэн эрх нь:

- Засгийн газрын бүх томоохон төслүүд ба бусад санал санаачилга, төслүүдийг зохицуулах ба тэдгээрт шаардагдах нөөц боломжийг хөдөлгөх;
- Засгийн газрын кабинет ба яамдуудад төслүүдийг хэрэгжүүлэх тухайд зөвлөмжөөр хангах;
- Яамдуудын төслүүдийг эхлэхээс нь дуусах хүртэл нь Санхүү ба Хөгжлийн Төлөвлөлтийн Яамны санхүүгийн хэмжигдэхүүн бүхий онол концепцтой уялдуулан туслах;
- Төслийн менежмент ба зохицуулалтын төрийн компьютерын системийг ашиглан төслийн хэрэгжилт ба чанарыг хянах;
- Бизнес ба Эдийн Засгийн Зөвлөлийн Хурлаас батлагдсан Үйл Ажиллагааны төлөвлөгөөнөөс гарсан философи ба шинэ бодлогын зарчмуудтай уялдуулсан бодлого, хууль ба дүрэм журмуудыг баримтлан удирдан чиглүүлэх ба зохицуулах;
- Ботсвана улсын олон улсад өрсөлдөх чадвар ба гадаадын хөрөнгө оруулалтыг татахтай холбоотой бүх асуудлуудаар цаг үргэлж нягтлан үзэх ба шаардлагатай үед засан залруулах интервенцүүдийг санал болгох;

- Ботсвана улсын Экспортын Хөгжил ба Хөрөнгө Оруулалтын Захиргаатай хамтран хувийн бизнесийн салбар ба олон улсын бизнесийн хооронд гүүр болох гэх зэрэг.

Хяналт ба үнэлгээний стратеги:

- Хяналт ба Үнэлгээний иж бүрэн, цэгцтэй тогтолцоог хөгжүүлэх;
- Бодлого боловсруулах ба нягтлан үзэх чиг шугамыг хөгжүүлэх;
- Ур чадварыг хөгжүүлэх: Ур чадварын хөгжил нь үр дүнтэй хяналт ба үнэлгээнд чухал зүйл юм.
- Яам тус бүр дээр Төслийн Менежментийн Албыг байгуулах. Тодорхой үе шат бүхий үнэлгээ хийх судалгааны төлөвлөгөө ба менежментийг хийж тус тусын холбогдох яамдыг бодитой бөгөөд үнэ цэнэтэй мэдээллээр хангах;
- Бодлого ба стратегийг уялдуулах;
- Мэдээллээр жигд хангах.

Тайлагнах үе шат:

- Засгийн Газрын Хэрэгжилт Зохицуулалтын Албанд түүний салбарууд нь улирал тутмын ажлын явцын тайлан өгнө.
- Засгийн Газрын Хэрэгжилт Зохицуулалтын Алба нь улирал тутмын ажлын тайланд шинжилгээ хийнэ.
- Дүн шинжилгээ хийсэн улирлын тайлангаар Байнгын Нарийн бичгийн дарга нарын хороо гэх зэрэг Хороодод илтгэл танилцуулга хийнэ.
- Улирал тутам Засгийн газрын кабинетын мэдээллийн тэмдэглэлийг өргөн мэдүүлнэ.
- Бүх салбарууд нь жил тутмын үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн шинжилгээ эсвэл өөрийгөө үнэлэх арга хэрэгслүүдийг хэрэглэнэ.
- 3-5 жил тутам цогц бодлого/хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн төгсгөл үед шуурхай дүн шинжилгээг хийж хэрэгжиж дууссаны дараа нь бүрэн судалгаа шинжилгээг хийж дүгнэлт гаргадаг байна.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол хэл дээр

- “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам” Жоди Золл Кусек, Рей С.Рист, 2010 он
- “Дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч зарим орны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга, туршлага” Харьцуулсан судалгаа (СТ-13/239), УИХ-ын Тамгын газар, СШХ, 2013 он.
- “Стратеги судлал” сэтгүүл, №54, 2011 он.
- “Хөгжлийн урт хугацааны бодлогын харьцуулсан шинжилгээ” Үндэсний хөгжлийн хүрээлэн, 2014 он.

Гадаад хэл дээр

- “Концепция долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2020 года” Утверждена распоряжением Правительства РФ от 17 ноября 2008 г. № 1662-р.
- Прогноз долгосрочного социально-экономического развития Российской Федерации на период до 2030 года. Март, 2013.

- Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 “Об Основах стратегического планирования в РФ”.
- Указ Президента РФ от 12 мая 2009 г. №536 “Об Основах стратегического планирования в РФ”.
- ФЗ от 20 июля 1995 г. №115-ФЗ “О государственном прогнозировании и программах социально-экономического развития РФ”.
- ФЗ Российской Федерации от 28 июня 2014 г. N 172-ФЗ “О стратегическом планировании в Российской Федерации”. www.rg.ru/
- Global finance сэтгүүл. www.gfmag.com/
- Planning Policy Statement, The Government Objectives for the Planning System, The United Kingdom, 2005.
- The English Planning System: An Overview, 2011, London.
- http://csis.org/files/media/csis/pubs/070712_jcp.pdf
- http://data.worldbank.org/indicator
- http://unpan1.un.org/
- www.adbi.org/files/
- www.tijoss.com/
- www.epu.gov.my/c/document_library/